



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/372

Хэрлэн сум

Байнгын байршил тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтууд, Засгийн газрын 2019 оны 313 дугаартай “Дүрэм батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батноров сумын нутаг дэвсгэрт Идэрмэг нэртэй газарт ашигт малтмалын ашиглалтын MV-013414 дугаартай тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй “ЭБГ” ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын газрын байнгын байршлыг хавсралтад заасан солбицлуудаар тогтоосугай.

2. “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг мөрдөж, стандартын дагуу тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хадгалах, агуулах аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг “ЭБГ” ХХК-д зөвлөсүгэй.


3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг газрын мэдээллийн санд бүртгэж, агуулахад тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт хяналт тавьж, иргэд аж ахуйн нэгжид газар олгохгүй байхыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Сүнгээ), Батноров сумын Засаг дарга (Б.Жавхланбаяр) нарт, тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, стандартын дагуу тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах, агуулах, тээвэрлэх, ашиглах ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Д.Батхүү)-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 28-ны дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

“ЭБГ” ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын газрын байнгын байршил

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	111	05	5.8	47	34	24.05
2	111	05	4.73	47	34	25.66
3	111	05	7.96	47	34	26.71
4	111	05	9.06	47	34	25.01